

## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ӨЛГИЙ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.05.10

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Баян-Өлгий аймаг дахь Өлгий нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 08/21 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа, Ц.Оюут, Ж.Нямдэлгэр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийг дуустал хугацаанд зайнаас дотоод аудитыг хийсэн.

Нисэх буудлын 2020 оны зардлын төсвийн төлөвлөгөөг нийт 1,301,936.2 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 1,233,876.4 мянган төгрөг байж нийт зардал 68,059.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 149 дугаар албан бичгээр тус нисэх буудлын 2020 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж, санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсанд тооцсон.

Баян-Өлгий аймаг дахь нисэх буудлын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ИНҮТ-өөс 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр баталсан. ИНҮТ-өөс тус нисэх буудлын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу хянаж, үнэлээгүй байна.

Баян-Өлгий аймаг дахь нисэх буудлын 2020 оны 9 дүгээр сараас 2021 оны 4 дүгээр сар дуустал хугацааны бараа материалын бүртгэлийг шалгаж үзэхэд тухайн нисэх буудлын санхүүгийн бүртгэлд ашиглах шаардлагагүй барааны бүлгийг ашиглаж бүртгэсэн байна.

Ээлжийн амралтаа бүрэн эдлээгүй 1-4 хоногийн өмнө ажилдаа эргэн орсон 7 ажилтны ажилласан хугацаанд нь цалин бодож олгосноос ээлжийн амралт, цалин давхацсан байна.

Зайнаас ажилласан ажилтнуудад үр дүнгийн нэмэгдлийг журамд заасан хувиар олгоогүй.

Өвлийн улиралд уурын зуухны галч нарыг 6 ээлжээр ажиллуулж байгаа нь тухайн галч нарын ажилласан цаг нь тухайн сарын ажлын балансад хүрэхгүй байдалд хүргэсэн байна. Өөрөөр хэлбэл ээлжээр ажилтнуудын цалинг бодохдоо ажлын цагийг нэгтгэн бодох журмыг хэрэгжүүлж, төсвийг хэмнэж ажиллаагүй.

Шилэн дансны тухай хуульд заасан хугацаа, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т ...Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн

бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно... гэж заасныг зөрчиж 19.0 сая төгрөгийн нүүрсийг шууд худалдан авсан.

Дотоод аудитын албанаас Баян-Өлгий аймаг дахь нисэх буудлын үйл ажиллагаанд 2020 онд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 96 хувьтай байна.

Нисэх буудлын Аюулгүй ажиллагаа, дотоод хяналтын баг 2021 онд хийх ажлын төлөвлөгөөндөө ХАБЭА-г хангах талаар 3 чиглэлээр 14 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар шалгаж үзэхэд 81 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 1, тус нисэх буудалд 8, нийт 9 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА